





МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ




Тус газраас 2021 оны 3-р сард Дэлхийн нягтлан бодогчдын холбооны дэргэдэх Улсын Секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан УСНББОУС-ын 2018 оны хэвлэл болох 40 стандартыг монгол хэл дээр орчуулан хэвлүүлж байгууллагуудад тараагаад байна.

Шинэчлэгдсэн болон шинээр гаргасан УСНББОУС 40 стандартын дагуу төсвийн байгууллагуудад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн журмыг 22 бүлэг, 180 гаруй хуудастайгаар шинэчлэн боловсруулж журмын төслийг Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-т заасны дагуу Сангийн яамны цахим хуудсанд <https://mof.gov.mn/discussion/1183> хаягаар байршууллаа.




Нягтлан бодогчдын мэдлэг ур чадвар нэмэгдэж, санхүүгийн тайланг олон улсын стандартын дагуу бэлтгэх, санхүүгийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй тайлагнах боломж бүрдүүлээ.



## “УСНББОУС”

2 боть



300 хувь хэвлүүлэн  
ТЕЗ, Их дээд  
сургуулиуд, төсөвт  
байгууллагуудад  
хүргүүлэв.

Цахим хувилбар болон видео хичээлийг Сангийн яамны [www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn) цахим сайтад байршууллаа.





УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт,  
УСНББОУС 30 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга,  
УСНББОУС 21 Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт,  
УСНББОУС 26 Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралт,  
УСНББОУС 32 Үйлчилгээний концессын хэлцэл,  
УСНББОУС 27 Хөдөө аж ахуй,  
УСНББОУС 24 Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн толилуулга,  
гэх мэт олон стандартуудын талаарх ойлголтыг шинээр оруулсан



## Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиас:

17.1.3.аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үндэсний болон холбогдох стандарт, журам баталж, мөрдүүлэх;

17.1.4.эдийн засгийн салбарын хэмжээнд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, заавар, аргачлал, маягтыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх;



Дараах бүх шалгуурыг хангасан улсын секторын байгууллага нь УСНББОУС, энэхүү зааврыг мөрдөнө.

- 1) Олон нийтэд үр өгөөж өгөх, орлого баялагийг дахин хуваарилах үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлага хүлээдэг;
- 2) Засгийн газрын бусад түвшнүүдээс авах татвар, шилжүүлэг, нийгмийн даатгалын шимтгэл, өр төлбөр буюу үйлчилгээний хөлсөөр өөрсдийн үйл ажиллагааг шууд ба шууд бусаар ихэвчлэн санхүүжүүлдэг;
- 3) Ашиг олох үндсэн зорилгогүй байх.

Сангийн сайдын тушаалаар “Улсын секторын байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Санхүүгийн тайлан, тодруулгын маягт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус батлахаар төлөвлөж байна.

# Нягтлан бодох бүртгэлийн бодлого

- НББ-г боловсруулах болон хэрэглэхдээ өөрийн мэргэжлийн шийдлийг ашиглах хэрэгтэй.
  - Хэрэглэгчдийн шийдвэр гаргалтын хэрэгцээнд хамааралтай байх
  - Найдвартай байх.
    - Байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл ба мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх
    - Хууль ёсны хэлбэрээс илүү эдийн засгийн мөн чанарыг илэрхийлэх
    - Төвийг сахисан
    - Хянамгай байх
    - Бүх материаллаг нөлөөг бүрэн илэрхийлсэн байх

- **Хөрөнгө**
  - ААН-ийн хяналтанд байдаг нөөц
  - өнгөрсөн үйл явдлын үр дүн
  - эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй орох урсгал
- **Өр төлбөр**
  - хүлээх үүргийн толилуулга
  - өнгөрсөн үйл явдлаас үүссэн
  - эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй гарах урсгал
- **Өмч = Хөрөнгөөс хасах нь өр төлбөр**



# Санхүүгийн тайлангийн элементүүди

- Тодорхойлолтод нийцсэн зүйлсийг дараах нөхцөлд хүлээн зөвшөөрөхийг хэлнэ

- Тухайн зүйлтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх эсвэл түүнээс бусдад шилжүүлэх магадлалтай ба
- Тухайн зүйлийн өртөг ба үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой байна.

- Магадлал- эдийн засгийн үр өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх тодорхой бус байдлын зэргийг тодорхойлох шалгуур болдог.

Тодорхой бус байдлыг зэргийг үнэлэхдээ үйл ажиллагаагаа явуулж буй орчны онцлог, санхүүгийн тайлан бэлтгэж байсан үеийн нотолгоонд үндэслэнэ.

Хэмжилтийн найдвартай байдал- өртөг эсвэл үнэ цэнийг тооцоолсон байх ёстой. /үндэслэлтэй хэмжилт хийж чадахгүй бол тайланд хүлээн зөвшөөрөхгүй, тэмдэглэлд тусгана./

Хүлээн зөвшөөрөх шалгуур нийцээгүй зүйлс дараагийн үйл явдлын үр дүнд дараагийн хугацаанд хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж болно.

элемент	Тусгагдах тайлан	Хэзээ хүлээн зөвшөөрөх
хөрөнгө	Санхүүгийн байдлын тайлан	эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай ба хөрөнгийн өртөг ба үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой.
Өр төлбөр	Санхүүгийн байдлын тайлан	эдийн засгийн ирээдүйн үр өгөөж аж ахуйн нэгжээс бусдад шилжих магадлалтай ба хийгдэх төлбөрийн дүнг найдвартай хэмжих боломжтой
орлого	Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	Хөрөнгийг нэмэгдүүлэх болон өр төлбөрийг бууруулах дүнг найдвартай хэмжих боломжтой эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг өсөлт
зардал	Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	Хөрөнгийг бууруулах болон өр төлбөрийг нэмэгдүүлэх дүнг найдвартай хэмжих боломжтой эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг бууралт

# Элементүү

## дийн

### ХЭМЖИЛТ

- Хэмжилт гэдэг нь санхүүгийн тайлангийн элементүүдийг хүлээн зөвшөөрч, санхүүгийн байдлын болон орлогын тайланд тусгах мөнгөн дүнг тодорхойлох үйл ажиллагаа юм.
- Санхүүгийн тайланд хэмжилтийн дараах суурь ашигладаг.
- ...

- Түүхэн өртөг- хэмжилтийн гол суурь боловч үнэлгээний бусад аргатай хамт хэрэглэнэ.
- Тайлант үеийн өртөг
- Боломжит үнэ цэнэ
- Өнөөгийн үнэ цэнэ
- Хэмжилтийн нийтлэг хоёр суурь байна:
  - түүхэн өртөг (тухайлбал, хөрөнгө худалдан авахад төлсөн дүн)
  - бодит үнэ цэнэ (тухайлбал, хамааралгүй талуудын хоорондын ажил гүйлгээгээр хөрөнгийн солилцох боломжтой дүн)



	бүлэг	агуулга
1	НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	1. зорилго, үндэслэл 2. үйлчлэх хүрээ 3. нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн зорилго 4. тайлагнагч байгууллага 5. санхүүгийн тайлангийн элементүүд 6. санхүүгийн тайлан дахь хүлээн зөвшөөрөлт 7. хэмжилтийн зорилго, суурь
2	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА	1. санхүүгийн тайлангийн зорилго, бүрэлдэхүүн хэсэг 2. тайлан бэлтгэх зарчим, ерөнхий шинж чанар 3-7. санхүүгийн тайлангууд 8. нягтлан бодох бүртгэлийн үе шат 9. анхан шатны баримт ба баримт эргэлт, файлын хадгалалт, хамгаалалт 10. дансны жагсаалтын төрөл, кодлох зарчим
3	АРИЛЖААНЫ БОЛОН АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО	1. орлогын ангилал 2. орлогын хүлээн зөвшөөрөлт 3. орлогын хэмжилт хүлээн зөвшөөрөлт 4. толилуулга ба тодруулга 5. ажил гүйлгээг бүртгэх журналын бичилтүүд



- Улсын секторын байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зорилго нь Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн журам, зааврын дагуу байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг бэлтгэхэд оршино.

УСНББОУС 35 “Нэгтгэсэн санхүүгийн тайлан”-ын 38 дахь параграфт “ хяналт тавигч байгууллага нь төсөөтэй нөхцөл байдал дахь ажил гүйлгээ ба үйл явдлын хувьд нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл бодлого баримталснаар нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэнэ.” гэж заасны дагуу улсын секторын байгууллагууд нь энэхүү нэгдмэл бодлогыг ашиглана.

Журмын 1.6-т Улсын секторын тайлагнагч байгууллага /цаашид байгууллага гэх/ энэхүү журмыг байгууллагынхаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болгон ашиглана.



1.23 Байгууллага нь энэхүү нэгдмэл бодлогын баримт бичигт үйл ажиллагааны онцлог шинж чанар болон үйл явдлын шинж байдлаас шалтгаалан шүүн тунгаалт хийх замаар мэргэжлийн шийдлээ ашиглан холбогдох стандартаар хүлээн зөвшөөрсөн тохиолдолд дараах зүйлсийг тодруулах байдлаар нэмэлт бодлогыг боловсруулж болно. Үүнд:

- 1) Сангийн сайдын тушаалаар батлагдсан дансны зааврын хүрээнд дансныг ангилах;
- 2) Материаллаг байдал нь байгууллага бүрийн тухайн нөхцөл байдалд харгалзан үзэж буй уг зүйлийн шинж төрөл ба дүнгийн аль алинаас хамаардаг./УСНББОУС-ын Үзэл баримтлалын 3.32/ Иймээс тодорхой төрлийн мэдээлэл нь материаллаг байх нийтлэг тоон босго шалгуурыг тусгайлан заах боломжгүй тул тухайн байгууллага нь мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлох;
- 3) Орлогын ажил гүйлгээ нь ялган тодорхойлж болох арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээний бүрэлдэхүүн хэсгүүдтэй эсэхийг тогтоохын тулд шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлох;





- 4) УСНББОУС нь тухайн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын зүйлсийг юу бүрдүүлэхийг зааж өгөөгүй тул байгууллагын тухайн тодорхой нөхцөл байдалд хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хэрэглэхдээ шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлно гэж заасан байдаг. Иймд стандартын заалтын дагуу тухайн санхүүгийн элементийн бүлэглэлд хамааруулан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг ангилах, **хяналтын системийн талаарх** асуудлыг байгууллагын бодлогодоо тодорхой заасан байна;
- 5) тодорхойгүй байдлын улмаас санхүүгийн тайлан дахь олон зүйлсийг нарийн оновчтой хэмжиж чадахгүй боловч зөвхөн ойролцоогоор тооцоолж чаддаг. Тооцоолол нь хамгийн сүүлийн үеийн байдлаар бэлэн байгаа, найдвартай мэдээлэлд үндэслэн шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлохыг агуулдаг;
- 6) Тухайн байгууллагын хувьд биет хөрөнгө болон биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааны тооцоолол нь ижил төсөөтэй хөрөнгүүдийн талаарх уг байгууллагын туршлагад үндэслэн шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлно.



	бүлэг	агуулга
4	ЗАРДАЛ, ЦАЛИНГИЙН БҮРТГЭЛ	1. зарлагын ангилал 2. хүлээн зөвшөөрөх шалгуур ба хэмжилт 3. толилуулга ба тодруулга 4. ажил гүйлгээг бүртгэх журналын бичилтүүд:
5	МӨНГӨН ХӨРӨНГӨ,	1. хамрах хүрээ 2. ангилал
6	САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ,	3. хүлээн зөвшөөрөлт, хэмжилт 4. үл хүлээн зөвшөөрөлт
7	АВЛАГА	5. толилуулга ба тодруулга 6. ажил гүйлгээг бүртгэх журналын бичилтүүд
8	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО,	1. хамрах хүрээ 2. ангилал 3. хүлээн зөвшөөрөлт, хэмжилт
9	БАРАА МАТЕРИАЛ	4. үл хүлээн зөвшөөрөлт 5. толилуулга ба тодруулга 6. ажил гүйлгээг бүртгэх журналын бичилтүүд



## Агуулахад байгаа хангамжийн материал



- Энэ хөрөнгийг тавьж олгосон үед нь шууд зардлаар хүлээн зөвшөөрнө.
- ямар хугацаанд тавьж олгох тухай бодлоготой байна. тухайлбал, нормын хувцасаар 2 жилд нэг удаа хангах,
- бичиг хэргийн зүйлс, цэвэрлэгээний материал, багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, ном, сэтгүүл, тооны машин, хогийн сав, ус буцалгагч, ТОГ


## Ашиглалтанд буй хангамжийн материал



- Нэг жилээс дээш ашиглалтын хугацаанд үйл ажиллагаанд ашиглагдах хангамжийн материал; Тодорхой ашиглалтын хугацаатай байх; Ихэвчлэн үйлчилгээ үзүүлэх албан тасалгаанд байрлуулдаг байх. Үндсэн хөрөнгөнд бүртгэх босго үнийн шалгуурт хүрэхгүй байх
- Жишээ нь ширээ, сандал, хөшиг, тавилга, толь, өлгүүр, сургалтын болон лабораторийн багаж хэрэгсэл, сурах бичиг....
- Тодорхой ашиглалтын хугацааны дараа тухайн хөрөнгөө зардлаар хүлээн зөвшөөрнө.



	бүлэг	агуулга
10	ҮНДСЭН ХӨРӨНГӨ,	1. хамрах хүрээ
11	БИЕТ БУС ХӨРӨНГӨ	2. ангилал 3. хүлээн зөвшөөрөлт, хэмжилт 4. үл хүлээн зөвшөөрөлт 5. толилуулга ба тодруулга 6. ажил гүйлгээг бүртгэх журналын бичилтүүд
12	ӨР ТӨЛБӨР,	1. хамрах хүрээ
13	САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР	2. ангилал 3. хүлээн зөвшөөрөлт, хэмжилт 4. үл хүлээн зөвшөөрөлт 5. толилуулга ба тодруулга 6. ажил гүйлгээг бүртгэх журналын бичилтүүд
14	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ,	1. хамрах хүрээ
15	ТҮРЭЭС	2. ангилал 3. хүлээн зөвшөөрөлт, хэмжилт 4. үл хүлээн зөвшөөрөлт 5. толилуулга ба тодруулга 6. ажил гүйлгээг бүртгэх журналын бичилтүүд





- Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангасан зөвхөн тавилга эд хогшлийн зүйлсийн хувьд 2 сая төгрөгөөс дээш төгрөгийн зүйлсийг үндсэн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх;

Дараа үеийн зарлагын хувьд өөрөөр хэлбэл их засварын зардал нь 50 сая төгрөгөөс дээш үед УСНББОУС 17-ын 24 дүгээр параграфын шаардлага хангасан тохиолдолд хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлнэ.



## Үндсэн хөрөнгийн ангилал

### Бүлэг 1

- томоохон, дангаараа материаллаг, илүү төрөлжсөн хөрөнгө,
- Жишээ: аж үйлдвэрийн тоног төхөөрөмж, тусгай зориулалтын барилга байгууламжийн томоохон бүрдэл хэсэг эсхүл Төр-Хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан олж авсан хөрөнгө
- Дэд бүтцийн хөрөнгө

### Бүлэг 2

- ижил төстэй шинж чанарыг үл харгалзан, илүү том, илүү өртөгтэй хөрөнгийн ангилал
- Жишээ нь: оффис, цэцэрлэг, сургууль эмнэлгийн барилга, агааржуулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл гэх мэт

### Бүлэг 3

- Бага үнэтэй олон зүйлсээс бүрддэг хөрөнгийн ангилал
- Жишээ: тавилга, оффисын тоног төхөөрөмж, машин тоног төхөөрөмж гэх мэт



## Бүлэг 1

- Мэдэгдэхүйц өртөг бүхий хэсэг тус бүрийг тусад нь элэгдүүлнэ. 59 дэх заалт
- УСНББОУС-17-ын 24 дэх заалт зарим хэсгийг тодорхой хэсгийг сольж орлуулах үед орлуулагдсан хэсгийг данснаас хасна. 82-87 дахь заалт

## Бүлэг 2

- хөрөнгийн ашиглалтын стандарт хугацаа, элэгдлийн аргыг мөрдөхдөө тусдаа хөрөнгө бүрийн үнэ цэнэ буурах, ашиглалтын хугацаа дуусахаас өмнө гарз гарах, ашиглалтаас хасах үед тохируулга хийсэн дансны үнийн хамт бүхэлд нь мөрддөг.

## Бүлэг 3

- ашиглалтын дундаж хугацаанд үндэслэн ашиглалтын стандарт хугацааг тогтоодог. Элэгдэлд, зүйл тус бүрийн дараагийн ашиглалтын хугацаа, нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагагүй.





## Үндсэн хөрөнгийн ангилал

### Бүлэг 1

- 67 дахь заалтаар ашиглалтын хугацааг жил бүрийн эцэст хянана.
- Ашиглалтын хугацааг өөрчлөнө.
- Үлдэгдэл өртөгтэй байна.
- Дахин үнэлгээний болон өртгийн загварыг ашиглана.

### Бүлэг 2

- 67 дахь заалтаар ашиглалтын хугацааг жил бүрийн эцэст хянана.
- Ашиглалтын хугацааг өөрчлөнө.
- Үлдэгдэл өртөгтэй байна.
- Дахин үнэлгээний болон өртгийн загварыг ашиглана.

### Бүлэг 3

- 67 дахь заалтаар ашиглалтын хугацааг жил бүрийн эцэст хянахгүй.
- Ашиглалтын хугацааг өөрчлөнө.
- Үлдэгдэл өртөггүй байж болно.
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн тохиолдолд заавал үнэ тогтоох шаардлагагүй.
- өртгийн загварыг ашиглана.



	бүлэг	агуулга
16	НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН, ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ, АЛДАА	<ol style="list-style-type: none"><li>1. нягтлан бодох бүртгэлийн бодлого</li><li>2. нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт</li><li>3. нягтлан бодох бүртгэлийн алдаа</li></ol>
17	ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨ	<ol style="list-style-type: none"><li>1. хамрах хүрээ</li><li>2. ангилал</li><li>3. хүлээн зөвшөөрөх шалгуур ба хэмжилт</li><li>4. бүртгэлийн валютаас өөр валютыг толилуулгад ашиглах</li><li>5. ажил гүйлгээг бүртгэх журналын бичилтүүд:</li></ol>
18	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ	<ol style="list-style-type: none"><li>1. концессын хөрөнгийн ангилал, хүлээн зөвшөөрөлт</li><li>2. концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт</li><li>3. концессын хөрөнгийг хэмжих ба үнэлэх</li><li>4. өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт</li><li>5. толилуулга ба тодруулга</li></ol>



	бүлэг	агуулга
19	БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ	1. хамрах хүрээ 2. хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт 3. хөрөнгийн ангилал, төрөл 4. толилуулга ба тодруулга
20	САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОЛИЛУУЛГА	1. төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлсэн толилуулга 2. төсвийн суурь, цар хүрээний тэмдэглэл тодруулга
21	ТАЙЛАНГИЙН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ	
22	ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА	



- Улсын секторын байгууллагын хувьд биологийн хөрөнгийг ихэвчлэн үйлчилгээ үзүүлэх буюу нийлүүлэх зорилгоор эзэмшдэг. Жишээ нь цагдаагийн байгууллагад ашиглаж буй морь ба нохой, амралт зугаалгын зорилгоор эрхлэн ажиллуулдаг парк, цэцэрлэгт хүрээлэн дэх ургамал ба мод хамаарна. Ийм биологийн хөрөнгийг биологийн хувьсал эсхүл үр шим хүргэлтийн улмаас түүний чанар болон тоо хэмжээнд орсон өөрчлөлтийг хэмжих ба хянан үнэлэх зорилгоор байнга удирдан зохицуулдаггүй учраас тэдгээрийг хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор эзэмшдэггүй гэж дүгнэж УСНББОУ-17-ын дагуу бүртгэнэ.



1. Санхүүгийн тайлангийн маягт жилийн эцэс болон улирлын тайлангийн маягтын ялгаа гаргах эсэх
  - а. жилийн эцэст иж бүрэн тайлан гаргах
  - б. улирлаар зөвхөн үндсэн 4 тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах /ямар тодруулга оруулах/  
Салбарын онцлог дансны бичилтийг бүрэн хамруулах